



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 11 өдөр

Дугаар A/07

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.


3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Шангри-Ла Улаанбаатар Хотел ХХК-ийн/ “Шангри-Ла Хотел” зочид буудлын 18/88, Нарантуул шилтгээн ХХК-ийн “Нарантуул” зочид буудлын 18/09, Агнай ХХК-ийн “Ска” зочид буудлын 18/46, Сод тулга ХХК-ийн “Сод” зочид буудлын 18/28, Хан тольт ХХК-ийн “Аттила” дэн буудлын 18/77, Мондрагони ХХК-ийн “Грийн” дэн буудлын 17/290, Түвшин дэвших ХХК-ийн “Эв” дэн буудлын 18/21, Мөнх-Алекс ХХК-ийн “Тайга” дэн буудлын 17/262, гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.


1150500079

4. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Х.Содномдэмбэрэл/-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 02
сарын 11 өдрийн А/07 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ 8936 1118263562

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2019.02.11

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Шангри-Ла Улаанбаатар Хотел ХХК	5149037	Шангри-Ла хотел	СБД-ийн, 1-р хороо, Олимпийн гудамж -19
2	Нарантуул шилтгээн ХХК	5010675	Нарантуул	ЧД-ийн, 2-р хороо, Баруун дөрвөн зам
3	Агнай ХХК	2113961	Ска	БГД-ийн 18-р хорооны Энэбишийн гудамж 89-р байр
4	Сод тулга ХХК	2675382	Сод	БЗД-ийн, 25-р хороо, Дамдинсүрэнгийн гудамж 75/02

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 02
сарын 11 өдрийн А/07 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284025 СБТ 8936 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2019.02.11

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Хан тольт ХХК	5498732	Аттила	СХД-ийн, 4-р хороо, 78 тоот
2	Мондрагони шим ХХК	5666848	Грийн	СХД-ийн, 13-р хороо, Залуусын гудамж
3	Түвшин дэвших ХХК	6012973	Эв	БЗД-ийн, 10-р хороо 2а хэсэг, ТЗ-ын гудамж 66 тоот
4	Мөнх-Алекс ХХК	5082919	Тайга	БЗД-ийн 2-р хороо, Их дарь эх 1-44

-ooOoo-